



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/548

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1./б/, 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хороо болон Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Монгол улсын санхүүгийн салбарын хөгжлийг дэмжих” төслийн хүрээнд 2017 оны 9 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд Орхон аймгийн Баян-Өндөр суманд Хадгаламж зээлийн хоршоодын удирдлагуудад зориулсан бүсчилсэн сургалт болон Орхон аймагт даатгалын болон банк бус санхүүгийн үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчлан танилцуулах өдөрлөгийг 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр А.Амарын талбайд тус тус зохион байгуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд шаардагдах 4996000 /Дөрвөн сая есөн зуун ерэн зургаан мянган/ төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын “Орон нутгийн Банк, ББСБ, ХЗХ, Даатгалын байгууллагуудтай хамтран ажиллах” зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг /-т зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг /-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны  
09 дүгээр сарын 17-ны өдрийн  
548 дугаар захирамжийн хавсралт



### СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Буудлын зардал	4өрөө*2хоног	70 000	560 000
2	Хоолны зардал	32хүн*2 удаа	20 000	1 280 000
3	Цайны завсарлага	32хүн* 2удаа	4 000	256 000
4	Заалны түрээс	2өдөр	700 000	1 400 000
	Нийт			3 496 000

### ӨДӨРЛӨГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Анонс хэвлүүлэх	1	250 000	250 000
2	АХА тэмцээний урамшуулал	1 хүн	50 000	50 000
3	Тв цацалт		100 000	100 000
4	Шатахуун / асар, сандал ширээ байрлуулах/	2 удаа	50 000	100 000
5	Боршур	500	2000	1 000 000
	Нийт			1 500 000